



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 4/108

Улаанбаатар хот

Автомашин шилжүүлэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.Цагдаагийн ерөнхий газрын Автобаазын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ОХУ-д 2008 онд үйлдвэрлэсэн, 13 293 100 /арван гурван сая хоёр зуун ерэн гурван мянга нэг зуу/ төгрөгийн балансын өртөгтэй, элэгдлээ бүрэн нөхсөн, 80514539 арлын, УБП 08-09 улсын дугаартай "Уаз-31512" маркийн автомашиныг Баянхонгор аймаг дахь цагдаагийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Дээрх автомашиныг данс бүртгэлээс хасахыг Автобаазын дарга /цагдаагийн хурандаа Ү.Зоригтбаатар/-д, бодит үнэлгээ тогтоон орлогод авч, данс бүртгэлд тусгахыг Баянхонгор аймаг дахь цагдаагийн газрын дарга /цагдаагийн хурандаа Б.Оюутболд/-д тус тус зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Санхүү, аж ахуйн албаны дарга /цагдаагийн хурандаа У.Энхтөр/-д даалгасугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН  
ХУРАНДАА

ХУУЛБАР ҮНЭН  
Захиргааны удирдлагын газрын дарга,  
цагдаагийн хурандаа



Ө.ЭНХТӨР

П.Оростогоо

0901643